



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГ,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 01 сарын 09 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах  
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.5, 6.4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын шаардлага хангахгүй болсон нийт 120,000,000.00 (нэг зуун хорин сая) төгрөгийн балансын үнэ, 106,068,492.88 (нэг зуун зургаан сая жаран найман мянга дөрвөн зуун ерэн хоёр төгрөг наян найман мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн ерөнхий захирал Ш.Энхтөрд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, сэлбэгээр ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН  
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТЭГЧ




Ц.НЯМ-ОСОР

Э.ЭРДЭНЭХИШИГ

0001340

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
 2018 оны 01 дүгээр сарын 09-ны өдрийн  
 03. дугаар тогтоолын хавсралт



ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,  
 АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ (ширхэг)	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Гематологийн анализатор (SYSMEX ХЕ-2100)	2010.01.01	1	120,000,000.00	120,000,000.00	106,068,492.88	13,931,507.12
	<b>Дүн</b>	-	<b>1</b>	<b>120,000,000.00</b> (нэг зуун хорин сая)	<b>120,000,000.00</b> (нэг зуун хорин сая)	<b>106,068,492.88</b> (нэг зуун зургаан сая жаран найман мянга дөрвөн зуун ерэн хоёр төгрөг наян найман мөнгө)	<b>13,931,507.12</b> (арван гурван сая есөн зуун гучин нэгэн мянга таван зуун долоон төгрөг арван хоёр мөнгө)